

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ
АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН
ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин(биелэлт)	Биелэлтийн хувь
	1.	2.	3.
1.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24/08 дугаар тогтоолыг баталсантай холбогдуулан 2025 оны I улиралд уг хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг боловсрууллахаад холбогдох албан хаагчдыг чиглүүлэх, нэгтгэх ажлыг зохион байгуулсан арга хэмжээний төслийг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газарт хургуулсан ба одоогоор Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй байна.	100
2.	Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагч болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 250114/08-32/01/20 дугаар хамтран ажиллах гэрээнд туссан байгууллагын чиг үүрэгт хамаарах 16 заалтыг хяналтад авч	100

		холбогдох хэлтэс нэгжүүдэд танилцуулан гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус гэрээнд зааснаар биелэлтийг бүтэн жилийн байдлаар 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр тусгасан.	
3.	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг сайжруулах;	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг цомхон, тогтвор суурьшилтай, үр дүнтэй, хариуцлагатай ажиллуулах болон төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын А/65 дугаар “Хяналтын улсын (ахлах) байцаагчийн эрх цуцлах, олгох тухай” тушаалаар Улсын байцаагч Л.Баярмааг улсын ахлах байцаагч болгон албан тушаал дэвшүүлсэн.	100
4.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	2025 онд төсөв 4,589,116,600 төгрөгөөр батлагдаж, хөтөлбөр арга хэмжээний дагуу үйл ажиллагааны нөхцөл байдлаар уялдуулан зарцуулж байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,725,650,200 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан байна. 2025 оны батлагдсан төсөвт 32,000,000 төгрөгийг зардлын бүлэг хооронд шилжүүлсэн байна. Газрын хэвийн үйл ажиллагааг хангахад 2025 онд санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангасан 1,371,896,668.86 төгрөгийн ажил гүйлгээний зарцуулалтыг данс бүртгэлд тусган ажиллаж байна. НХХААГазарт бүртгэлтэй 6 авто тээврийн хэрэгслийг АТБӨЯХАТаварт 659,568 төгрөг, зам ашигласан төлбөр 775,000 төгрөг, агаарын бохирдол 40,400 төгрөг, оношлогоонд 88,000 төгрөг, ЖХДаатгалд 585,792 төгрөг тус тус төлж хамруулсан байна. Газрын төлбөрт 11,871,323 төгрөг төлөхөөс 2025 онд 9,500,000 төгрөгийн төсөв батлагдсан. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг	100

		стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shiendans.gov.mn цахим хуудсанд 2025 оны 01-06 сарын байдлаар 23 нэр төрлийн 79 мэдээлэл оруулахаас 79 мэдээлэл оруулж нийтэд ил тод болгосон байна.	
5.	Хууль, дүрмээр хүлээсэн чиг үүрэг, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээх ба Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд төлөөлж, гарсан үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцах;	Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хангах хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус чиг үүргийн хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээнүүдийг тусган төлөвлөсөн ба байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 93.9 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
6.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиглах;	Тус арга хэмжээ нь манай байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй болно.	-
7.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиглах;	Эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргын 7 шуурхай хурал, Ерөнхий менежерийн 4 удаагийн шуурхай хурлаас өгөгдсөн 25 үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гаргаж албан бичгээр болон цахим системд тайлагнаж ажигласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг заасан хугацаанд тайлагнан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиглаж байна.	100
8.	Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;	Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хангах хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус чиг үүргийн хэрэгжилтийг хангах холбогдох арга хэмжээнүүдийг тусган төлөвлөсөн ба байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт 93.9 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
9.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг	Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 12 заалт бүхий төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр	

батлах, хэрэгжүүлэх;	газрын даргаар батлуулсан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт албан хаагчдын 2025 оны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгааг цахимаар зохион байгуулж, судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулсан ба 2025 онд 65 албан хаагчийг сургалтад хамрагдахаар төлөвлөсөн. Эхний хатас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 44 албан хаагчийг 16 нэр төрлийн сургалтад 100 хувь хамруулсан. 1.Баримт бичиг боловсруулах арга зүй сургалтад 4 албан хаагч, 2.Өргөдөл гомдлын системийн хэрэглээ сургалтад 2 албан хаагч, 3. Төрийн албан хэргийг кирил болон үндэсний хос бичгээр зохион бүрдүүлэхэд анхаарах асуудал сургалтад 6 албан хаагч, 4.Монгол бичгийн цахим сургалтад 5 албан хаагч, 5.Манлайлах ур чадвар сургалтад 5 албан хаагч 6.ERP системийн хэрэглээ, сургалтад 2 албан хаагч, 7."Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд зохион байгуулагдах "Жендер" зорилгот сургалтад 2 албан хаагч, 8.Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системийн ашиглалт, баримт боловсруулах, шийдвэрлэх, хяналт тавих тухай сургалтад 3 албан хаагч, 9.Орчин үеийн удирдах ажилтны манлайлал, өндөр бүтээмжтэй баг бүрдүүлэх сургалтад 1 албан хаагч, 10.MS Excel /анхан, дунд шат, ахисан шат/ сэдэвт сургалтад 2 албан хаагч, 11.Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх нь сэдэвт сургалтад 2 албан хаагч, 12.Төрийн албан хаагчийн ажлын зохион байгуулалт, харилцааны соёл сэдэвт сургалтад 1 албан хаагч, 13.Урам зоригтойгоор төрийн албаны үнэ цэнийг бүтээхүй сургалтад 2 албан хаагч, 14.Хурал, уулзалтыг амжилттай, үр дүнтэй явуулахад технологи ашиглах чадвар сургалтад 4 албан хаагч, 15.Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалтад 2	100
-----------------------------	--	------------

		албан хаагч 16.MNS ISO 9001:2015 дотоод аудитор бэлтгэх сургалтад 1 албан хаагч тус тус хамруулсан.	
10.	Алба хаагчдын сахилга харилцаага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах	1.Албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Ажлын байран дахь хүний эрх” сэдвийн хүрээнд танилцуулга бэлтгэж газрын 69 албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан. Мөн байгууллагын албан хаагчдын хууль хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж Монгол улсын Хүний эрхийн Үндэсний комиссын Тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 338 дугаар албан бичгээр төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдад “Хүний эрхийн суурь мэдлэг олгох” сэдвээр хөтөлбөрт сургалт авах тухай хүсэлт хүргүүлэн ажиллалаа. 2.Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Ёс зүйн дэд хорооны дарга Ц.Цэрмаа баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Ёс зүйн дэд хорооноос шинээр ажилд орсон 7 албан хаагчдад чиглүүлэх сургалтыг 1 удаа, байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын дунд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг сурталчлан таниулах, төрийн албан хаагчийн хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлэх, цахим орчин дахь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамт олныг идэвхжүүлэх, нийтэч байдлыг бэхжүүлэх зорилгоор “Цахим орчин дахь ёс зүй” сэдэвт (контент, шторк) уралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ны хооронд амжилттай зохион байгуулсан.	100
11.	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;	ХХААХҮҮ, ЭМЯ-ны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан “Согууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бүс хяналт шалгалт хийх” удирдамжийн дагуу	90

		Ulaanbaatar.mn цахим сайтын Онлайн бизнес төвийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр дүгнэлт гаргуулахаар 1403 аж ахуйн нэгж хүсэлт ирж, 8.11.2 кодтой хяналтын хуудсаар бага эрсдэлтэй дүгнэгдсэн 628 аж ахуйн нэгжийн худалдааны газарт, 8.10.4 кодтой хяналтын хуудсаар бага эрсдэлтэй дүгнэгдсэн 426 аж ахуйн нэгжийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт улсын (ахлах) байцаагчийн үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, дунд болон их эрсдэлтэй дүгнэгдсэн 75 аж ахуйн нэгжид дүгнэлт гаргах боломжгүй талаар татгалзсан хариу өгч, бичиг баримтын зөрчилтэй, давхардуулан ирүүлсэн 165 хүсэлтийг буцааж, 97 хүсэлт шийдвэрлэгдэхээр судлагдаж байна.	
12.	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны 20 дугаар зөвлөмжийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Ажлын сахилга харилцлага, дэг журмыг сайжруулах тухай" 01 дүгээр албан даалгаврын 3 дахь заалтын дагуу 1.Бодлогын хүрээнд- 4 2.Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд- 2 3.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд- 5 4.Архив, албан хэрэг хөтлөлт өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд- 3 5.Хүний нөөцийн бодлогын хүрээнд- 5 заалт бүхий ажлын зөвлөмжийн дагуу ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар бэлтгэн ажиллаж байна.	70
13.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах;	Хотын хөгжлийн индексийн 4 бүлэг 6 төрлийн 86 үзүүлэлтээс байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 3 үзүүлэлт хамаарагддаг ба байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсанаар эдийн засгийн бүлэгт хамаарах хүнсний хангамжийн чанар, хүнсний хангамжийн хүртээмж, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтэд	100

		шууд нөлөөлөх юм.	
14.	Хотын хөгжлийн индексийн тооцох суурь, анхдагч мэдээллийн чанарыг сайжруулж, орон зайн болон шаардлагатай статистик мэдээллийг Нийслэлийн статистикийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран боловсруулж, хүрсэн үр дүнг 2025 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох;	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг 15 үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн байдлаар боловсруулан Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвд 02 дугаар сарын 07-нд хугацаанд хүргүүлэн ажигласан.	ХБ
15.	Чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;	ХХААХҮЯ, ЭМЯ-ны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 2025 оны 08-00-02/02, 10—00/14, 08-00-02/03 удирдамжийн хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь, Сотгууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архивдан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор сотгууруулах ундаагаар худалдах түүгээр үйлчлэх хүсэлт ирүүлсэн 1403, сургууль, цэцэрлэгээс ирүүлсэн 15, мах махан, гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх 13 хүсэлтийг хүлээн авч хяналт шалгалт хийж 628 аж ахуйн нэгжийн худалдааны газарт, 426 аж ахуйн нэгжийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт, 5 сургууль, 6 цэцэрлэгийн гал тогоо, хүүхдийн хоол хүнс, мах махан бүтээгдэхүүн, гурил гурилан бүтээгдэхүүний үйл ажиллагаа эрхлэгч 7 аж ахуйн нэгж, иргэнд үйл ажиллагааны дүгнэлт гаргаж, шаардлага хангахгүй ажлын байртай 2 сургуульд 8 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн их эрсдэлтэй үнэлэгдсэн 4 аж ахуйн нэгж, 2 иргэнд татгалзаж, сотгууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх дунд болон их эрсдэлтэй дүгнэгдсэн 75 аж ахуйн нэгжид дүгнэлт гаргах боломжгүй талаар татгалзсан хариуг албан бичгээр өгч, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авч ажиглаж байна.	100
16.	Чиг үүргийн хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг өөрийн	Нийслэлийн хүн амын гол нэрийн хүнсний хангамжийн тооцооллыг хийж, холбогдох илтгэл, танилцуулгыг бэлтгэж, "Хүнсний хангамж,	

	цахим хуудас болон төрийн үндэсний судалгааны нэгдсэн системд тухай бүр нийтэлж, дүн шинжилгээ хийх;	аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус тогтоолын хүрээнд зохион байгуулагддаг төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалтад нийслэлийн хүнсний хангамжийг сайжруулахад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломжуудын талаарх бодлогыг боловсруулж, танилцуулахаар бэлтгэл хангаад байна. 5 дугаар сард төлөвлөгдсөн байсан тус уулзалт тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.	100
17.	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;	Хяналтын хэлтэст 274 албан бичиг, 82 өргөдөл, гомдол хүлээн авч 265 албан бичиг, 76 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулж, 9 албан бичиг, 6 өргөдөл, гомдол шийдвэрлэгдэх шатанд явагдаж байна. Өргөдөл гомдлыг дунджаар ажлын 10 хоногт барагдуулсан байна.	90
18.	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнт тайлагнах, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хургуулсан чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга	Эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг даргын 7 шуурхай хурал, Ерөнхий менежерийн 4 удаагийн шуурхай хурлаас өгөгдсөн 25 үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр гаргаж албан бичгээр болон цахим системд тайлагнаж ажигласан.	100

	хэмжээг авч хэрэгжүүлэх;		
19.	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах	"Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт холбогдох журамд заасан хугацаанд хүргүүлэн ажиглаж байна.	100
20.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, өөрийн цахим хуудас болон олон нийтэд мэдээлэх;	1. Байгууллагын https://hhaag.ub.gov.mn/ гэсэн Website-ийг 5 сард шинэчилж хуучин байсан мэдээ мэдээллийг шинэ вэбсайтад байршуулсан. 2025 оны хагас жилийн байдлаар нийт 21 мэдээ мэдээлэл оруулсан байна. 2. Байгууллагын https://www.facebook.com/www_hhaag.ub.gov.mn/ гэсэн фейсбүүк пэйж хуудсанд 2025 оны хагас жилийн байдлаар нийт 68 мэдээ мэдээлэл байршуулан ажиглаж байна.	100
21.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shlendans.gov.mn цахим хуудсанд 2025 оны 01-06 сарын байдлаар 23 нэр төрлийн 79 мэдээлэл оруулахаас 79 мэдээлэл оруулж нийтэд ил тод болгосон байна.	100
22.	Гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газартай зөвшилцөж, уялдуулах;	ХХААХҮЯам, Бүгд Найрамдах Солонгос улсын Хангёний Үндэсний Их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны төвтэй хамтран "Монгол улсад ухаалаг хүлэмжийн үндэсний цогцолбор, сургалтын төв байгуулах" төслийг 2024 оны III-р улиралд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газарт хүргүүлэн, тус төсөл дэмжигдэн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорт байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиглаж байна. /Төсөвт өртөг 3,7 сая \$/	100
23.	Хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээний талаарх	Нийслэлийн хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэн нөөцөлсөн махыг 446 цэгээр худалдан борлуулж	100

	мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх;	байгаа ба тус мэдээллийг Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын веб сайт болон пейж хуудас, Ulaanbaatar.mn болон мэдээллийн цахим сайтуудаар хүргэж иргэд олон нийтэд дамжуулж ажилласан.	
24.	Нийслэлийн Засаг даргын "2025 оныг Бүтээн байгуулалтын жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх;	ХХААХҮЯ-м, Бүгд Найрамдах Солонгос улсын Хангений Үндэсний Их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны төвтэй хамтран "Монгол улсад ухаалаг хүлэмжийн үндэсний цогцолбор, сургалтын төв байгуулах" төслийг Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорт байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. /Төсөвт өртөг 3,7 сая \$/	100
Дундаж хувь			97.7

ТАНИЛЦСАН:
 НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
 ДАРГА  Х.ЭРДЭНЭБИЛЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
 ЗТСХ-ийн ДОТООД ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
 МЭРГЭЖИЛТЭН  З.АЮУШ